"АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

ХУРЛЫН ТОВ

Огноо: 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр

Цаг: 15:00-17:10

Хурал болсон газар: 17 давхар, Сентрал Тауэр, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Улаанбаатар хот.

ХУРЛЫН ИРЦ

Хурлын дарга: Ч. Ганхуяг /ТУЗ-ийн дарга/

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын тоо: 146

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигч нарын саналын эрхтэй хувьцааны тоо: 13,835,322

Хурлын ирц: 57.21%

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ

1. Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах;
3. ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах;
4. 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах (саналын хуудас);
5. Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах;
6. ТУЗ-ийн гишүүдийг сонгох (саналын хуудас);
7. ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах тухай (саналын хуудас).

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл:

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын 25/1 тоот тогтоол: Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн саналын эрхтэй нийт 24,185,222 ширхэг энгийн хувьцаанаас 13,835,322 ширхэг буюу 57.2 хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд оролцож байна. Иймд ирц хүрсэн, хурал хүчин төгөлдөр болж байна.

Хурлын дарга Ч.Ганхуяг:

Хурлыг нээж, хурлын дэгийг танилцуулж баталснаар хурлыг эхлүүллээ. Компанийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн даргын хувьд Нэгдэлийн эрхэм зорилгын талаар товч танилцуулга хийв.

Хуралд ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг, ТУЗ-ийн гишүүн, хувьцаа эзэмшигч Бруно Рашле, гишүүн М.Сэргэлэн, Гүйцэтгэх захирал Б.Золбоо болон компанийн удирдах албан тушаалтнууд оролцлоо.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 1: Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах тухай - Гүйцэтгэх захирал Б.Золбоо танилцуулгыг хийв.

2024 онд группын хэмжээнд нийт 44 компани үйл ажиллагаа явуулж байна. Ажилчдын тоо 8.3 хувиар өсөж 286 ажилтантай болсон. Давхардсан тоогоор 108,000 хувьцаа эзэмшигчтэй болжээ. 2024 онд 332,000 Ардкойны данс идэвхтэй байсан ба Ардкойны дүрмийн дагуу идэвхгүй харилцагчдийн урамшууллыг тухайн харилцагчид мэдэгдэж, олгосон Ардкойныг буцаан татаж авсан байна.

2024 онд Ард Кредит шинээр хувьцаа болон нээлттэй бонд гаргасан. Ард Даатгал нь Монгол улсдаа хамгийн их хүнийг даатгасан компани болсон. Ард апп-ийн хэрэглэгч болгоныг Ард Актив-ийн гишүүн болгох зорилготой байна.

Ард Санхүүгийн Нэгдэл нь банкны, даатгалын болон хөрөнгө оруулалтын банкны буюу санхүүгийн компаниудаа шууд эзэмшдэг бол санхүүгийн бус компаниудаа Хөвсгөл ХК-ийн доор шилжүүлэх үйл явц үргэлжилж байна. Мөн Өндөрхаан ХК-ийн хувьцааг худалдаж авч даатгалын тусгайлсан групп компани болгох зорилготойгоор эхний ээлжинд Тэтгэвэрийн санг шилжүүлсэн байсан бол Ард Даатгалын 50 хувийг шилжүүлэх ажил эцэслэгдэж байна.

2017 оноос хойш Крипто Үндэстэн сан байгуулж хаалттай хүрээнд үйл ажиллагааг нь эхлүүлсэн бол 2021 оноос хойш бүх крипто компаниудыг нэгдсэн удирдлага дор оруулж Крипто Үндэстэн нээлттэй хувьцаат компани доор нэгтгэлээ.

2024 онд Банкны кластерийн хувьд 185 орчим тэрбум төгрөгийн зээлийг олгосон байна. Мөн нийт банкны кластерийн хөрөнгө нь 172 тэрбумд хүрсэн нь 50 орчим хувиар өссөн үзүүлэлт байлаа. Цэвэр ашиг нь 4.8 тэрбум байгаа нь мөн адил 50 хувийн өсөлтийг харуулж байна. Хөрөнгө оруулалтын кластерийн хувьд 69 орчим тэрбум төгрөгийн арилжааг хийж, 31 тэрбум төгрөрийн хөрөнгийг удирдан ажиллажээ. Даатгалын кластер 55 тэрбум төгрөгийн борлуулалт хийж 82.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтын багцийг удирдан ажилласан.

Ард Санхүүгийн Нэгдэлийн бүтцийн өөрчлөлт 2 жилийн өмнөөс хийгдэж эхэлсэн ажил. Энэ ажлын сүүлийн шат буюу компанийг 2 хуваах ажлыг батласан. Хөвсгөл ХК 86.6 сая ширхэг хувьцааг нэмж гаргаж, өнөөдрийн байдлаар 12.6 тэрбумын үнэлгээтэй компани болсон. Тухайн компанийн оноосон нэрийг Ардын хөрөнгө оруулалтын нэгдэл болгон өөрчилж, уул уурхай, эрчим хүч, үл хөдлөхийн салбаруудад төсөл хэрэгжүүлж эхлэхээр төлөвлөж байна.

Ард Санхүүгийн Нэгдэл хувьцаа эзэмшигчдээсээ хувьцааг нь эргүүлэн худалдан авч төлбөрт нь үнэт цаас буюу Хөвсгөлийн хувьцаагаар төлнө. 1 ш Ард Санхүүгийн Нэгдэлийн хувьцааг Хөвсгөлийн 20 ш хувьцаагаар солих боломжийг олгож байгаа. Бид Ард Санхүүгийн Нэгдэлийн нийт гаргасан хувьцааны 15 орчим хувийг эргүүлэн худалдаж авах ба хувьцаа эзэмшигчид өөрийн хувьцааны 50 хүртэлх хувийг худалдах боломжтой. 5 сарын 30-нд эцсийн байдлаар тус захиалгыг хааж жагсаалтаа гарган холбогдох гүйлгээг хийлгэх хүсэлт өгнө.

Группын хэмжээнд онцлох үйл явдлыг товчхон дурдвал Сентрал тауэр-ийн 1 давхарт салбараа нээсэн бол Ард апп Дэлхийн Эдийн Засгийн Форумаас шилдэг төлбөрийн шийдлээр шалгарсан. Мөн кластер бүрээр онцлох үйл явдлыг товч, компанийн засаглалын бүтэц, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, менежментийн баг болон холбоотой компаниудын удирдлагыг танилцууллаа.

Санхүүгийн тайланг дэлгэрэнгүй танилцуулсны зэрэгцээ компанийн топ 20 хувьцаа эзэмшигчийн бүтцийг танилцууллаа.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 2: 2024 оны санхүүгийн тайланд хийгдсэн хараат бус аудитын байгууллагын дүгнэлтийг танилцуулах тухай – Хараат бус Аудитор Эрдэнэцог танилцуулав.

Өөрсдийн аудитын компанийн талаар товч танилцуулж, Ард Санхүүгийн Нэгдэлтэй жилийн тайланд 2024 оны 11 сараас 2025 оны 4-р сар хүртэл тодорхой өдрүүдэд хамтран ажилласан. Аудитын үнэлгээг хувьцаа эзэмшигчдийн хурлын материалд тодорхой тусгасныг тайлбарлан танилцууллаа.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 3: ТУЗ-ийн үйл ажиллагааны тайланг танилцуулах тухай – ТУЗ-ийн дарга Ч.Ганхуяг танилцуулав.

ТУЗ-ийн ээлжит болон ээлжит бус хурал 4 удаа, хороодын хурал 12 удаа болж, эчнээ санал хураалтыг 9 удаа явуулж, нийт 23 асуудал шийдвэрлэгджээ. Эдгээрээс онцлох шийдвэр, чухал асуудлыг танилцуулж, мөн ТУЗ-ийн дэргэдэх хороодын онцлох зөвлөмжийг танилцууллаа.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 4: 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай - Хурлын дарга Ч.Ганхуяг санал хураалтын "Саналын хуудас"-ыг танилцуулж, Гүйцэтгэх захирал Б.Золбоо дүгнэлтийг танилцууллаа.

"Ард Санхүүгийн Нэгдэл" ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх дүгнэлтийг Компанийн тухай хууль, Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн дүрмийн холбогдох заалтын дагуу Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар хэлэлцэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулж байна. Ард Санхүүгийн Нэгдэл үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш хувьцаа эзэмшигчид, харилцагчидтайгаа хамтран 11 жилийн хугацаанд 44 компанийн нэгдэл болон өргөжиж, өнгөрсөн 5 жилийн хугацаанд цахим шилжилтийг хийж, сүүлийн 2 жилийн хугацаанд бүтцийн өөрчлөлтийг амжилттай хийснээр 2024 онд бүрэн цахим банкны үйлчилгээ үзүүлэгч санхүүгийн нэгдэл болж, бүтээлч түйвээлтээр манлайлагч финтек нэгдэл болох алсын хараандаа үе шаттай ойртсоор байна.

Энэ жилийн онцлох үйл явдлыг товчхон дурдвал: - Бүтцийн өөрчлөлттэй холбоотойгоор Хөвсгөл ХК руу санхүүгийн бус компаниудаа шилжүүлж, Хөвсгөл ХК нь өрийг хувьцаагаар солих төслөө боловсруулан зохицуулагч байгууллагаас зөвшөөрлөө авч, нэмэлт хувьцаа нь 2025 оны 3 сард эргэлтэд оров; - Өндөрхаан ХК руу даатгалын кластерын компаниудыг төвлөрүүлж, зах зээл дээрх бусад оролцогчидтой нэгдэн нийлүүлэх зорилгоор даатгал болон тэтгэврийн сангаа шилжүүлэх бүтцийн өөрчлөлтийн эцсийн шатанд ирэв; - Ард Кредит FPO буюу олон нийтэд хувьцаагаа дахин санал болгож, 8.9 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлснээс гадна анх удаагаа нээлттэй бонд гаргаж, 13.5 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлж чадлаа. Салбартаа анх удаа дебит картаа харилцагч нарынхаа гарт хүргэсэн онцгой үйл явдал тохиов; - Ард Даатгалын 30 жилийн ойн баяр тохиохын зэрэгцээ салбартаа хамгийн олон даатгалын гэрээ хийж, анх удаа тогтвортой хөгжлийн тайланг танилцуулав. Мөн гурван жолооч бүрийн нэгийг даатгаж байгаагаа дуулгахад таатай байна; - Ард Секюритиз гадаад, дотоодын 13 андеррайтингийн ажлын хүрээнд 85 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлэхээс гадна уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаанд оролцох тусгай зөвшөөрөл авав; - Монголын хүн амын 32 хувь нь Ард Аппын данс нээж, өдөр бүр Ард Аппаараа дамжуулан 300 гаруй зээл олгож, цаг тутамд 20 сая төгрөгийн хадгаламж татаж, өдөртөө хөрөнгийн зах зээл дээр 423 арилжаа зуучилж, өдөрт 10,000 гаруй гүйлгээг боловсруулж байна;

Хөндлөнгийн аудитын дүгнэлт хийлгүүлэхээр Грант Торнтон олон улсын аудитын компанийг сонгон ажиллуулсан бөгөөд "Ард Санхүүгийн Нэгдэл" ХК 2024 онд төлөвлөсөн зорилтоо биелүүлэхийн тулд өөрсдийн нөөц бололцоогоо бүрэн ашиглаж "Хангалттай" ажилласан гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэлээ.

Өөр санал хүсэлт байхгүй гэснээр дараагийн хэлэлцэх асуудалд орлоо.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 5: Ногдол ашиг хуваарилах эсэх тухай ТУЗ-ийн шийдвэрийг танилцуулах тухай - Гүйцэтгэх захирал Б.золбоо танилцуулав.

Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 25/01 тоот ээлжит хурлын тогтоолоор 2024 оны санхүүгийн жилд хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн. Учир нь компанийн үйл ажиллагааны үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийг нэмэгдүүлэх зорилготой болно. Нээлттэй хувьцаат компани нь хувьцаа эзэмшигчдийнхээ нэгж хувьцааны үнэ цэнийг өсгөх нь эрхэм зорилго байдаг.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 6: ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай - Гүйцэтгэх захирал Б.Золбоо танилцуулав.

Ард Санхүүгийн Нэгдэлийн ТУЗ-ийн гишүүдийн 8 нь улиран сонгогдохоор нэр дэвшсэн бол нэг ердийн гишүүнд Гүйцэтгэх захирал Б.Золбоо нэр дэвшиж байна.

Гүйцэтгэх захирал Б.Золбоо ТУЗ-д нэр дэвшигчдийн танилцуулгыг хийлээ.

Гүйцэтгэх захирал Б.Золбоо санал хураалтын “Саналын хуудас”-ыг танилцууллаа.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ 7: ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах тухай

ТУЗ-ийн төсөвт ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал болон томилолтын зардал багтсанаар 2025 оны төсвийг 426 сая төгрөг гэж төсөвлөв.

Гүйцэтгэх захирал Б.Золбоо санал хураалтын "Саналын хуудас"-ыг танилцууллаа.

Өөр санал хүсэлт байхгүй гэснээр санал хураалтын ажиллагаанд орлоо. Санал хураалтын дүн гарч байх хугацаанд ТУЗ-ийн гишүүн, хувьцаа эзэмшигч Бруно Рашле-тэй ярилцлага хийв.

Санал хураалтын дүнг нэгтгэж дууссан тул хурлыг үргэлжлүүлж, тооллогын комиссын зүгээс санал хураалтын дүн болон Тооллогын комиссын тогтоолыг танилцуулахыг Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэлээс хүслээ.

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл:

Хэлэлцэх асуудал-1: 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай

Санал хураалтын дүн

Нийт саналын эрхтэй хувьцаа	Зөвшөөрсөн		Татгалзсан		Түтгэлзсэн	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
13,835,322	13,695,501	98.99%	51	0.0004%	415	0.003%

Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Хэлэлцэх асуудал-2: ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай

Санал хураалтын дүн

Нэрс	Зөвшөөрсөн	
	Тоо	Хувь
Чулууны Ганхуяг	13,835,322	100.0%
Бруно Рашле	13659337	98.73%
Авирын Сүхдорж	13644029	98.62%
Одончимэдийн Одбаяр	13701823	99.04%
Батбилэгийн Золбоо	13735382	99.28%
Михаил Зелдович	13663104	98.76%
Арно Вентура	13638370	98.58%
Мөнх-Очирын Сэргэлэн	13664807	98.77%

Роланд Нэш	13719408	99.16%

Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Хэлэлцэх асуудал-3: ТУЗ-ийн 2025 оны төсвийг батлах тухай тухай

Санал хураалтын дүн

Нийт саналын эрхтэй хувьцаа	Зөвшөөрсөн		Татгалзсан		Түтгэлзсэн	
	Тоо	Хувь	Тоо	Хувь	Тоо	Хувь
13,835,322	13755654	99.42%	3111	0.02%	520	0.004%

Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Тооллогын комиссд баярлалаа. Дэгийн дагуу ХЭ-ийн хурлаас гарсан шийдвэрийг танилцуулна. (ХЭ-дийн хурлын тогтоолуудыг уншиж танилцуулав)

Хурал 17:10 минутад өндөрлөв.

ХУРЛЫН ДАРГА Ч.ГАНХУЯГ